



МОНГОЛ УЛСЫН ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

---

ЭРСДЭЛИЙН АУДИТЫН ТАЙЛАН

**“МОН АТОМ” ТӨРИЙН ӨМЧИТ ХЯЗГААРЛАГДМАЛ ХАРИУЦЛАГАТАЙ  
КОМПАНИЙ САНХҮҮГИЙН УДИРДЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГАА**

**АНХАН ШАТНЫ БАРИМТГҮЙ ИХ ХЭМЖЭЭНИЙ АВЛАГА, ӨГЛӨГИЙГ  
ДАНСНААС ШУУД ХАСЧЭЭ**

Улаанбаатар хот

## АГУУЛГА

### Тайланг бэлтгэсэн:

### ҮАГ-ын Гүйцэтгэлийн аудитын газар

Газрын захирал бөгөөд тэргүүлэх аудитор

М.Давааням

Аудитын менежер:

Л.Эрдэнэчулуун

Ахлах аудитор

Б.Долгорсүрэн

Аудитор

Г.Мөнхчимэг

### Гэрээгээр хамтран ажилласан:

Эйч Эл Би Монголиа Аудит ХХК-ийн Захирал

Ч.Энхтуяа

Аудитын менежер

М.Нурболат

Аудитор

Э.Билгүүн

2017 оны 6 дугаар сар

Уг тайланг ҮАГ-ын Веб сайтаас үзнэ үү:

[www.audit.mn](http://www.audit.mn)

Аудитын тайлантай холбоотой асуудлаар нэмж тодруулах, асууж лавлах зүйл байвал 263755, 262151, 261456 дугаарын утсаар харилцана уу.

### ХАЯГ:

Үндэсний аудитын газар  
Засгийн газрын 4 дүгээр байр,  
Бага тойруу-3,  
Улаанбаатар-15160  
Монгол Улс

|                                                                                                     |     |
|-----------------------------------------------------------------------------------------------------|-----|
| Хүснэгтэн мэдээллийн товъёог.....                                                                   | 2   |
| Графикан мэдээллийн товъёог.....                                                                    | 2   |
| Товчилсон үгсийн тайлбар.....                                                                       | 2   |
| Аудит хийсэн үндэслэл, зорилт, хамарсан хүрээ, арга зүй, стандартын мэдэгдэл, хүндрэл бэрхшээл..... | 3-5 |

|                       |   |
|-----------------------|---|
| Ерөнхий мэдээлэл..... | 6 |
|-----------------------|---|

### Бүлэг 1. Аудитаас өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлээгүйгээс зөрчил, дутагдал давтагдсаар байна

|                                                                                       |   |
|---------------------------------------------------------------------------------------|---|
| 1.1 Компаний удирдлага зөрчил, дутагдлыг арилгах ажил зохион байгуулаагүй байна ..... | 7 |
| 1.2 Аудитаас өгсөн зөвлөмжийн 41.7 хувийг хэрэгжүүлээгүй байна.....                   | 8 |

### Бүлэг 2. “Мон Атом” ХХК хөрөнгө оруулалтыг бүрэн бүртгээгүй, санхүүгийн тайланд үнэн зөв тусгаагүй байна

|                                                                                                                          |      |
|--------------------------------------------------------------------------------------------------------------------------|------|
| 2.1 “Мон Атом” ХХК хувь нийлүүлсэн хөрөнгө оруулалтыг бүрэн бүртгээгүй, санхүүгийн тайланд үнэн зөв тусгаагүй байна..... | 9-10 |
|--------------------------------------------------------------------------------------------------------------------------|------|

### Бүлэг 3. Авлага, өр төлбөрийг анхан шатны баримтгүйгээр данснаас хасч, нийт өр төлбөрийн 81.2 хувийг харилцагч байгууллагатай тооцоо нийлж, баталгаажуулаагүй байна

|                                                                                                                                       |       |
|---------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|-------|
| 3.1 Авлага, өр төлбөрийг анхан шатны баримтгүйгээр данснаас хасчээ.....                                                               | 11-12 |
| 3.2 Нийт өр төлбөрийн 81.2 хувийг хөрөнгө оруулсан компани болон харилцагч байгууллагатай тооцоо нийлж, баталгаажуулаагүй байна ..... | 12    |

### Бүлэг 4 Компаний удирдлага хамтран ажиллах гэрээний санхүүжилт, зээлийн эргэн төлөх эх үүсвэр, үр ашгийг тооцоогүйгээс Монгол Улсад 7.5 тэрбум төгрөгийн өр төлбөр үүсгэсэн байна.

|                                                                                                                                                                       |       |
|-----------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|-------|
| 4.1 Компаний тухай хуулийг зөрчин хамтран ажиллах гэрээ байгуулжээ.....                                                                                               | 13-14 |
| 4.2 Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийг зөрчин сонгон шалгаруулалт явуулахгүйгээр шууд гэрээ байгуулжээ..... | 15    |
| 4.3 Эргэн төлөх эх үүсвэр, үр ашгийг тооцохгүйгээр зээл авч, их хэмжээний өр төлбөр үүсгэсэн байна.....                                                               | 16    |
| 4.4 Зээлийн хүү болон ханшийн зөрүүг нягтлан бодох бүртгэлд үнэн зөв тусгаагүй байна.....                                                                             | 16    |

|                       |    |
|-----------------------|----|
| Аудитын дүгнэлт ..... | 17 |
|-----------------------|----|

|                       |       |
|-----------------------|-------|
| Аудитын зөвлөмж ..... | 18-19 |
|-----------------------|-------|

|                          |    |
|--------------------------|----|
| Тайлангийн хавсралт..... | 20 |
|--------------------------|----|

|                                             |    |
|---------------------------------------------|----|
| Монгол Улсын Ерөнхий аудиторовн тушаал..... | 21 |
|---------------------------------------------|----|

### Хүснэгтэн мэдээллийн товъёог

|                   |                                          |
|-------------------|------------------------------------------|
| <b>Хүснэгт 1.</b> | Санхүүгийн тайланд өгсөн аудитын дүгнэлт |
| <b>Хүснэгт 2.</b> | Аудитаас өгсөн зөвлөмжийн хэрэгжилт      |
| <b>Хүснэгт 3.</b> | Зарцуулалтын тайлан                      |

### Графикан мэдээллийн товъёог

|                  |                |
|------------------|----------------|
| <b>График 1.</b> | Нийт өр төлбөр |
|------------------|----------------|

### Товчилсон үгсийн тайлбар

|               |                                               |
|---------------|-----------------------------------------------|
| <b>АДБОУС</b> | Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт |
| <b>НӨАТ</b>   | Нэмэгдсэн өртгийн албан татвар                |
| <b>НДШ</b>    | Нийгмийн даатгалын шимтгэл                    |
| <b>ХХК</b>    | Хязгаарлагдмал хариуцлагатай компани          |
| <b>ХК</b>     | Хувьцаат компани                              |
| <b>ХХОАТ</b>  | Хувь хүний орлогын албан татвар               |
| <b>СТОУС</b>  | Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт    |
| <b>ҮАГ</b>    | Үндэсний аудитын газар                        |
| <b>ТУЗ</b>    | Төлөөлөн удирдах зөвлөл                       |

## **Аудит хийсэн үндэслэл**

Аудитыг Гүйцэтгэлийн аудитын газрын 2017 оны үйл ажиллагааны төлөвлөгөө, “Мон Атом” ХХК-ий “Хүсэлт гаргах тухай” 2017 оны 2 дугаар сарын 6-ны өдрийн 01/10 дугаар албан бичгийг үндэслэн Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.2-т тодорхойлсон бүрэн эрхийн хүрээнд хийлээ.

## **Аудитын зорилт**

“Мон Атом” ХХК-ий санхүүгийн удирдлагын үйл ажиллагаанд эрсдэлийн аудит хийж, дүгнэлт гарган зөвлөмж боловсруулж холбогдох байгууллага, албан тушаалтанд танилцуулахад аудитын зорилт чиглэгдсэн.

Аудитын зорилтыг хангахын тулд дараах чиглэлээр аудитыг гүйцэтгэлээ.Үүнд:

- Санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн зөрчил, дутагдал, өгсөн зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлсэн ажлын үр дүн;
- “Мон Атом” ХХК болон хөрөнгө оруулсан компани хоорондын ажил гүйлгээг үнэн зөв бүртгэсэн эсэх;
- Урт болон богино хугацаат өр төлбөрийг үнэн зөв, бүрэн бүртгэж тайлагнасан эсэх;
- Хөрөнгө оруулалт болон зээл, бусад санхүүжилтээс Монгол улсад учирч болзошгүй өр төлбөр, зардал, алдагдал үүссэн эсэх.

## **Аудитын хамарсан хүрээ**

Аудитад “Мон Атом” ХХК-ий 2009-2016 оны санхүүгийн тайлангаар илэрхийлэгдсэн мөнгөн хөрөнгө, бараа, материал, үндсэн хөрөнгө, авлага, өглөгийн журнал, анхан шатны баримтууд, үндсэн үйл ажиллагааны тайлан, үндсэн болон аж ахуйн үйл ажиллагааны явцад байгуулсан гэрээ, хэлэлцээрүүд, бусад холбогдох баримт бичгүүдийг хамрууллаа.

## **Аудитын арга зүй, стандартын мэдэгдэл**

Аудитыг Төрийн хяналт шалгалтын стандарт, Гүйцэтгэлийн аудитын удирдамж (АДБОУС 3000-3100) болон Санхүүгийн аудитын удирдамж (АДБОУС 1000-1800)-ийг ашиглан гүйцэтгэлээ.

“Мон Атом” ХХК-ий удирдлага, холбогдох албан тушаалтантай ярилцлага хийх, тайлбар, тодруулга авах, үйл ажиллагааны болон санхүүгийн тайланд дүн шинжилгээ хийх, анхан шатны баримт материалыг түүвэрлэн шалгах, тулган баталгаажуулах зэрэг арга зүйг ашиглан цуглуулсан нотлох баримтад судалгаа, харьцуулалт, дүн шинжилгээ хийж, нэгтгэн аудитын дүнг боловсруулж, түүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж өглөө.

Төрийн хяналт шалгалтын стандарт, Гүйцэтгэлийн аудитын удирдамжид заасны дагуу аудитын дүн, дүгнэлтэд дэмжлэг болох нотлох зүйлс, холбогдох мэдээ, судалгааг ажлын баримт материалд хавсаргав.

## **Аудитын шалгуур үзүүлэлт, хугацаа**

Аудитад дараах хууль, эрх зүйн актыг шалгуур үзүүлэлт болгон ашиглав.  
Үүнд:

- Компаний тухай хууль
- Хөдөлмөрийн тухай хууль
- Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хууль
- Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль
- Цөмийн энергийн тухай хууль
- Ашигт малтмалын тухай хууль
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль
- Санхүүгийн тайлангийн хайгуул үнэлгээний хөрөнгө СТОУС-6
- Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт 1,8,18,21,24,28,37,38
- Сангийн сайдын 2012 оны 77 дугаар тушаалаар баталсан “Аж ахуйн нэгжийн санхүүгийн тайлан, тодруулгыг бэлтгэх заавар”
- Сангийн сайдын 2011 оны 12 дугаар тушаалаар баталсан “Ашигт малтмалын хайгуулын болон ашиглалтын зардлыг нягтлан бодох бүртгэлд бүртгэх журам”
- “Мон Атом” ХХК-ий нягтлан бодох бүртгэлийн бодлого
- “Мон Атом” ХХК-ий дүрэм, хөдөлмөрийн дотоод журам

Аудитыг УАГ-ын Гүйцэтгэлийн аудитын газрын захирал бөгөөд тэргүүлэх аудитор М.Давааням удирдаж, аудитын менежер Л.Эрдэнэчулуун үе шатны болон чанарын хяналтыг хэрэгжүүлж, ахлах аудитор Б.Долгорсүрэн, аудитор Г.Мөнхчимэг нар гүйцэтгэсэн ба “Эйч Эл Би Монголиа Аудит” ХХК гэрээгээр хамтран ажиллан тодорхой асуудлыг шалгаж, дүгнэлт гаргалаа.

## **Хүндрэл, бэрхшээл**

Аудитын явцад нотлох зүйл бүрдүүлэх, мэдээлэл олж авах, мэдээллийн эх сурвалжийг бүрэн тодорхойлоход дараах хүндрэлүүд учирсан болно. Тухайлбал,

1. Дараах баримт бичгүүдийг эмхэлж цэгцлээгүй, архивын нэгж үүсгэж хадгалаагүйгээс задгай баримтаас нотлох зүйл олж үзэхэд цаг хугацаа их зарцуулагдсан. Үүнд:
  - Тус компаний 2009-2016 оны Гүйцэтгэх захирлын тушаал;
  - Төлөөлөн удирдах зөвлөлийн хурлын тэмдэглэл, тогтоолууд;
  - Хөрөнгө оруулагч, харилцагч байгууллагатай байгуулсан гэрээ, хэлэлцээрүүд;
  - Ажиллагсадтай байгуулсан хөдөлмөрийн гэрээ;
  - Байгууллагаас гадагш явсан болон гаднаас хүлээн авсан албан бичгүүд;
  - Ажил хүлээлцсэн актууд;
2. Одоогийн ажилтнууд компаний өмнөх үйл ажиллагааны талаар мэдээлэл бага байгаагаас шалтгаалан асууж тодруулах, лавлагаа авах боломж бүрдээгүй.
3. Компаний 2009-2014 он хүртэлх нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагааг гар аргаар, 2014-2016 оны эхний хагас жил хүртэл “Бааз” гэх санхүүгийн програмаар боловсруулж, санхүүгийн тайланг бэлтгэсэн боловч өмнөх нягтлан бодогч Л.Батзориг ажлаас чөлөөлөгдөхдөө албан ёсоор ажлаа

хүлээлгэн өгөөгүйгээс санхүүгийн болон бусад үйл ажиллагаатай холбогдох баримтууд гарын үсэг, тамга, тэмдгээр бүрэн баталгаажуулаагүй.

4. Аудитын явцад нягтлан бодох бүртгэлийн журнал, ерөнхий дэвтэр, гүйлгээ балансыг хуучин ажиллаж байсан нягтлан бодогчоос файлаар хүлээн авч танилцахад тус мэдээллүүд нь Нягтлан бодох бүртгэлийн болон санхүүгийн тайлагналын олон улсын стандарт, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Сангийн сайдын баталсан журам, зааварт нийцүүлж боловсруулагдаагүй байв.
5. 2016 оны 9 дүгээр сарын 1-нээс томилогдон ажиллаж байгаа нягтлан бодогч Н.Цэгмид 2016 оны 3, 4 дүгээр улирлын нягтлан бодох бүртгэлийн журнал, ерөнхий дэвтрийг хөтлөхгүйгээр санхүүгийн тайланг гаргасан тул санхүүгийн мэдээллийг шалгах, үлдэгдлийг баталгаажуулах боломжгүй байлаа.

**Ерөнхий мэдээлэл:**

Монгол Улсын Засгийн газрын 2009 оны 45 дугаар тогтоолоор “Мон Атом” Төрийн өмчит Хязгаарлагдмал хариуцлагатай компанийг байгуулсан байна.

Засгийн газрын 2016 оны 80 дугаар тогтоолоор батлагдсан “Төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдэд төрийн өмчийн төлөөллийг хэрэгжүүлэх журам”-ын 2.6-д *“Эрдэнэс Монгол” ХХК-ийн харьяа төрийн өмчийн оролцоотой “Эрдэнэс Таван толгой” ХК болон “Эрдэнэс Оюу толгой” ХК, “Багануур” ХК, “Шивээ-Овоо” ХК, “Мон-Атом” ХХК зэрэг төрийн өмчит хуулийн этгээдийн Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга, гишүүнийг Засгийн газрын 2016 оны 104 дүгээр тогтоолоор баталсан “Эрдэнэс Монгол хязгаарлагдмал хариуцлагатай компанийн дүрэм”-ийн 11.8<sup>1</sup>-д заасан журмын дагуу томилж, чөлөөлнө.* гэж заасныг үндэслэн “Мон Атом” ХХК-ий төрийн өмчийн төлөөллийг “Эрдэнэс Монгол” ХХК хэрэгжүүлэн ажиллаж байна.

Анх “Мон-Атом” ХХК-ий Төлөөлөн удирдах зөвлөлийн 2009 оны 03 дугаар тогтоолоор тус компаний зохион байгуулалтын бүтцийг 2 алба, 2 хэлтэс, 1 тасагтай, 25 орон тоотой байхаар баталж байсан.

2017 оны байдлаар компаний Төлөөлөн удирдах зөвлөлийн 2016 оны 7 дугаар сарын 28-ны өдрийн 17 дугаар тогтоолоор бүтэц, орон тоог шинэчлэн 5 орон тоотой ажиллахаар баталсан байна.

---

<sup>1</sup> Засгийн газрын 2016 оны 2 дугаар сарын 15-ны өдрийн “Дүрэм шинэчлэн батлах тухай” 104 дүгээр тогтоолоор баталсан “Эрдэнэс Монгол” хязгаарлагдмал хариуцлагатай компаний дүрэм”-ийн 11.8-д “Компани нь охин болон хараат компани дахь хувьцааны хэмжээ, үйл ажиллагааны чиглэлийг харгалзан тухайн компанийн Төлөөлөн удирдах зөвлөлд өөрийн төлөөллийг томилон ажиллуулах бөгөөд ийнхүү томилохдоо эрчим хүч, уул уурхайн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага болон Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын төлөөллийг оролцуулна.” гэж заасан байна.

## Бүлэг 1. Аудитаас өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлээгүйгээс зөрчил, дутагдал давтагдсаар байна

Тус компаний 2009-2016 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд Үндэсний аудитын газрын захиалгаар дараах аудитын компаниуд аудит хийж, дүгнэлт гаргажээ. Үүнд:

Хүснэгт 1. Санхүүгийн тайланд өгсөн аудитын дүгнэлт

| ТАЙЛАНТ<br>ОН | АУДИТ ХИЙСЭН КОМПАНИЙН НЭР      | ӨГСӨН ДҮГНЭЛТИЙН<br>ХЭЛБЭР |
|---------------|---------------------------------|----------------------------|
| 2009          | “Стандарт дүгнэлт аудит” ХХК    | Хязгаарлалттай             |
| 2010          | “Стандарт дүгнэлт аудит” ХХК    | Хязгаарлалттай             |
| 2011          | “Дөлгөөн Хайрхан Уул аудит” ХХК | Хязгаарлалттай             |
| 2012          | “Дөлгөөн Хайрхан Уул аудит” ХХК | Хязгаарлалттай             |
| 2013          | “Сүлд Аудит” ХХК                | Хязгаарлалттай             |
| 2014          | “Санхүүч Аудит”                 | Хязгаарлалттай             |
| 2015          | “Од бүртгэл Аудит” ХХК          | Хязгаарлалттай             |
| 2016          | “Од бүртгэл Аудит” ХХК          | Татгалзсан                 |

Эх сурвалж: УАГ-ын 2009-2016 онд хийсэн санхүүгийн аудитын архивын баримт

Хүснэгтээс харахад тус компаний 2009-2015 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд “хязгаарлалттай” дүгнэлт өгч, 2016 онд дүгнэлт гаргахаас татгалзсан байна.

### 1.1. Компаний удирдлага зөрчил, дутагдлыг арилгах ажил зохион байгуулаагүй байна

1.1.1. Компаний удирдлага аудитаас өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлэх талаар санаачлага гаргаагүй, тухай бүр ажил зохион байгуулж, хэрэгжүүлээгүйгээс дараах зөрчил, дутагдал давтагдсаар байна. Тухайлбал,

**2015 он:** “Ураниум Индастри” ХК-тай 2012 онд байгуулсан Хамтран ажиллах гэрээ”-ний дагуу Баруун-1 талбайд ураны хүдэржилтийн бүс ялгаж, үнэлгээ өгөх зорилгоор 2.0 сая доллар зарцуулсан боловч хийсэн ажлын тайлан, үнэлгээ хийсэн баримт материал байхгүй байна;

**2016 он:** 2012 онд байгуулсан хамтран ажиллах гэрээний дагуу “Ураниум индастри” ХК-аас авсан 2.0 сая долларыг урт хугацаат өр төлбөр, 1.9 тэрбум төгрөгийн эрэл хайгуул, тандан судалгааны ажлын зардлыг биет бус /хайгуул үнэлгээний/ хөрөнгө гэж бүртгэж тайлагнасан; “Мон Чех Ураниум” ХХК-д зээлийн эх үүсвэрээр хөрөнгө оруулсан 51.0 мянган ам.долларыг хөрөнгө оруулалтаар бүртгээгүй;

Анхан шатны баримт болон дэмжих баримтын зөрчилтэй 49.3 сая төгрөгийн гүйлгээ хийсэн, нягтлан бодох бүртгэлд 15.8 сая төгрөгийн гүйлгээ тусгагдаагүй, цалин, НДШ, ХХОАТ-ын тооцооллыг 12.4 сая төгрөгийн зөрүүтэй тус тус санхүүгийн тайланд тусгасан ;

Тайлант онд зорилтот түвшин, зардлын хязгаарыг баталж өгөөгүй байхад хандив, бэлэг, баяр ёслол тэмдэглэн өнөөрүүлэхэд 14.0 сая төгрөгийг зээлийн эх үүсвэрээр санхүүжүүлж, зарцуулсан; Жилийн эцсийн санхүүгийн тайланг нягтлан бодох бүртгэлийн журнал, ерөнхий дэвтэрийг зохих ёсоор хөтлөөгүй санхүүгийн тайланг гаргасан.

1.1.2. Компаний удирдлага, албан тушаалтнууд ажлаас чөлөөлөгдөж, аудитаас өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулаагүй, зөрчил, дутагдалыг давтан гаргасан албан тушаалтнуудад ажлын хариуцлага тооцуулах боломжгүй байна.

Цаашид компаний удирдлага, Төлөөлөн удирдах зөвлөлд анхаарч ажиллах талаар зөвлөмж өглөө.



## 1.2. Аудитаас өгсөн зөвлөмжийн 41.7 хувийг хэрэгжүүлээгүй байна.

1.2.1. “Мон-Атом” ХХК-ий удирдлагад 2009-2015 оны санхүүгийн тайлангийн аудитаас нийт 36 зөвлөмж өгсөн байна. Үүнд:

Хүснэгт 2. Аудитаас өгсөн зөвлөмжийн хэрэгжилт

| Он              | өгсөн зөвлөмж /тоогоор/ | Арвилан хэмнэх, үр ашиг, үр нөлөөг сайжруулах | зөвлөмжийн ангилал             |                                          | зөвлөмжийн хэрэгжилт       |              |              |
|-----------------|-------------------------|-----------------------------------------------|--------------------------------|------------------------------------------|----------------------------|--------------|--------------|
|                 |                         |                                               | Бүртгэл тайлагналтай холбоотой | Хууль тогтоомжийн хэрэгжилттэй холбоотой | Дотоод хяналтыг сайжруулах | хэрэгжсэн    | хэрэгжээгүй  |
| 2009            | 3                       |                                               | 1                              | 2                                        |                            | 3            |              |
| 2010            | 3                       |                                               | 1                              | 1                                        | 1                          | 3            |              |
| 2011            | 4                       |                                               | 1                              | 2                                        | 1                          | 3            | 1            |
| 2012            | 5                       |                                               | 1                              | 3                                        | 1                          | 3            | 1            |
| 2013            | 6                       |                                               | 3                              | 3                                        |                            | 6            |              |
| 2014            | 7                       | 1                                             | 3                              | 3                                        |                            | 3            | 5            |
| 2015            | 8                       | 2                                             | 6                              |                                          |                            |              | 8            |
| <b>нийт дүн</b> | <b>36</b>               | <b>3</b>                                      | <b>16</b>                      | <b>14</b>                                | <b>3</b>                   | <b>21</b>    | <b>15</b>    |
| <b>хувиар</b>   |                         | <b>8.3%</b>                                   | <b>44.4%</b>                   | <b>38.9%</b>                             | <b>8.3%</b>                | <b>58.3%</b> | <b>41.7%</b> |

Эх сурвалж: УАГ-ын 2009-2016 онд хийсэн санхүүгийн аудитын архивын баримт

1.2.2. Хүснэгтээс харахад нийт зөвлөмжийн 44.4 хувь нь бүртгэл, тайлагналтай холбоотой, 38.9 хувь нь хууль, тогтоомжийн хэрэгжилттэй холбоотой, 8.3 хувь нь арвилан хэмнэх, үр ашиг, үр нөлөөг сайжруулах, 8.3 хувь нь дотоод хяналтыг сайжруулах чиглэлээр өгсөн байна.

Аудитаас өгсөн нийт зөвлөмжийн 58.3 хувийг хэрэгжүүлж, 41.7 хувийг хэрэгжүүлээгүй байна.

1.2.3. Аудитаас өгсөн байгууллагын болон санхүүгийн үйл ажиллагаанд чухал нөлөөтэй, зөрчил, дутагдал давтагдан гарахаас сэргийлсэн дараах зөвлөмжүүд хэрэгжээгүй байна. Тухайлбал,

**2011 он:** “Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль”-д заасны дагуу эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшинг Төрийн өмчийн хороогоор батлуулж ажиллах, Зээлийн санхүүжилтээс өөр санхүүжилтийн эрх үүсвэрийг шийдвэрлүүлэх;

**2014 он:** “Эрдэнэс Монгол” ХХК-д төлөх өр төлбөрийг хүүгийн төлбөрөөс тусад нь бүртгэж, тайлагнах, тус компаний өр төлбөрийг барагдуулах;

Цалингийн болон нийгмийн даатгалын шимтгэл, хувь хүний орлогын албан татварын өр төлбөрт тооцогдох хүү, торгууль, алданги үүсэх эрсдэлтэй тул холбогдох байгууллагад танилцуулж, барагдуулах асуудлыг шийдвэрлүүлэх;

**2015 он:** Хайгуул үнэлгээний хөрөнгөөр санхүүгийн тайланд тусгасан 1,927,177,212 төгрөгийн тандан судалгааны ажил хайгуул үнэлгээний хөрөнгө болох эсэхийг тодорхойлж, хэрвээ хайгуул үнэлгээний хөрөнгө болохгүй бол тандан судалгааны зардал гэж үзэн хуримтлагдсан үр дүнд залруулга хийх;

“Мон Чех-Ураниум” ХХК 2015 оны 6 дугаар сард байгуулагдсан тул 2.0 сая долларын урт хугацаат өр төлбөрийг хааж, хамтарсан компани руу “Ураниум Индастри” ХК-ийн оруулсан хөрөнгө оруулалтаар шилжүүлж бүртгэх;

“Мон Чех Ураниум” ХХК-ий дансанд оруулсан 51.0 мянган ам.долларын хөрөнгө оруулалтыг өр төлбөр болон хамтарсан компанид оруулсан хөрөнгө оруулалтаар бүртгэж, залруулга хийх;

Гүйцэтгэх захиралтай байгуулсан “Хөлсөөр ажиллах гэрээ”-ний дагуу цаашид зээл авахдаа тухайн зээлийн зориулалт, нөхцөл, хүүгийн зардал нь компанийн үйл ажиллагаа, санхүүгийн байдалд хэрхэн нөлөөлөхийг судалж ТУЗ-ийн хурлаар хэлэлцүүлэн зөвшөөрөл авч байх;

Гадаад валютаар хийгдэх гүйлгээний ханшийн зөрүүгээс үүссэн олз, гарзыг бодит, бодит бусаар ялган аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тайланд толилуулах.

## **Бүлэг 2. “Мон Атом” ХХК хувь нийлүүлсэн хөрөнгө оруулалтыг бүрэн бүртгээгүй, санхүүгийн тайланд үнэн зөв тусгаагүй байна**

2016 оны жилийн эцсийн байдлаар “Мон Атом” ХХК нь “Гурван сайхан” ХХК-ий нийт хувьцааны 15 хувь буюу 1,500.0 мянган төгрөг, “Төв-Азийн Уран” ХХК-ий нийт хувьцааны 21 хувь буюу 750,552.2 мянган төгрөг, “Мон Чех Ураниум” ХХК-ий нийт хувьцааны 51 хувь буюу 51.0 мянган ам.долларыг тус тус эзэмшиж байна.

### **А. “Мон-Чех Ураниум” ХХК-д оруулсан хөрөнгө оруулалт**

2.1.1. Засгийн газрын 2015 оны 202 дугаар тогтоолыг үндэслэн 2015 оны 6 дугаар сарын 12-ны өдөр “Мон Атом” ХХК, “Ураниум Индастри” ХК-тай “Хувьцаа эзэмшигчдийн гэрээ”-г байгуулж, “Мон-Чех Ураниум” ХХК-ийг хамтран байгуулсан байна.

2.1.2. “Мон-Чех Ураниум” ХХК-ий дүрмийн 5 дугаар бүлгийн 5.2-т “Компаний гаргах эрхтэй нийт хувьцааны тоо 100,000 /нэг зуун мянган/ ширхэг энгийн хувьцаа байх ба тус бүр нь 1 ам.долларын нэрлэсэн үнэтэй байна”, 5.5-д “Мон Атом” ХХК нь 51,000 ширхэг хувьцааг, “Ураниум Индастри” ХК 49,000 мянган ширхэг хувьцааг тус тус эзэмшинэ” гэж заасан байна.

2.1.3. “Мон Атом” ХХК-ий 2015 оны 6 дугаар сарын 16-ны өдөр “Ураниум Индастри” ХК-тай байгуулсан 01 дугаартай “Зээлийн гэрээ”-ний 3.1<sup>2</sup>-д заасны дагуу 51.0 мянган ам.долларыг “Мон Чех Ураниум” ХХК-д шилжүүлсэн нь Төрийн өмчийн хорооны 2012 оны 302 дугаар тогтоолоор баталсан “Мон Атом” ХХК-ий дүрмийн 7 дугаар зүйлийн 7.1<sup>3</sup>-т заасныг зөрчсөн байна.

Төрийн өмчийн хорооноос хувь нийлүүлсэн хөрөнгө оруулалтыг зээлээр санхүүжүүлэх зөвшөөрөл аваагүйгээс “Мон Атом” ХХК “Зээлийн гэрээ”-ний дагуу шилжүүлсэн 51.0 мянган ам.долларыг “Мон Чех Уран” ХХК-д хувь нийлүүлсэн хөрөнгө оруулалт болон “Ураниум Индастри” ХК-д төлөх өр төлбөрөөр бүртгээгүй, санхүүгийн тайланд тусгаагүй байна.

Иймд дээрх асуудлыг Төлөөлөн удирдах зөвлөлд танилцуулж, холбогдох зөвшөөрлийг авч, “Мон Чех Уран” ХХК-д хувь нийлүүлэх хөрөнгө оруулалт болон “Ураниум Индастри” ХК-д төлөх өр төлбөрөөр залруулан бүртгэж, санхүүгийн тайланд тусгах шаардлагатай байна.

### **Б. “Төв Азийн уран” ХХК-д оруулсан хөрөнгө оруулалт**

2.1.4. Төрийн өмчийн хорооны 2009 оны 5 дугаар сарын 28-ны өдрийн 204 дүгээр тогтоолоор “Төв Азийн уран” ХХК-ий нийт эзэмшлийн 21 хувийг “Мон Атом” ХХК-д эзэмшүүлсэн байна.

2.1.5. “Төв Азийн уран” ХХК-ий улсын бүртгэлийн гэрчилгээнд бүртгэгдсэн хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ 2009 оны 10 дугаар сарын 12-ны өдрийн байдлаар

<sup>2</sup> Энэхүү гэрээнд гарын гарын үсэг зурсан өдрөөс хойш ажлын 5 хоногийн дотор эхний төлбөр болох 51.0 мянган ам.доллар нь “Мон-Чех Ураниум” ХХК-ий данс уруу шилжигдэх ёстой. Энэ нь зээлдэгчийн анхны хувь нийлүүлсэн хөрөнгө буюу “Мон-Чех Ураниум” ХХК-ийг үүсгэн байгуулах үед хувь нийлүүлэгчийн компанийн бүртгүүлэх хөрөнгөд өөрийн хувьцааны эзэмшлийн хувь хэмжээгээр хувь тэнцүүлэн хувь нийлүүлэх хөрөнгө болно.

<sup>3</sup> Компаний эрх барих дээд байгууллага нь Хувьцаа эзэмшигчдийн хурал байх бөгөөд Засгийн газрын шийдвэрийн дагуу компанийг хувьчлах хүртэл энэ үүргийг Төрийн өмчийн хороо хэрэгжүүлнэ.

3,574,058.0 мянган төгрөг байсан бөгөөд “Мон-Атом” ХХК-ий төрийн эзэмшлийг 750,552.2 мянган төгрөгөөр санхүүгийн тайланд бүртгэгдэхээр байхад тус компани 755,928.1 мянган төгрөгөөр буюу 5,375.9 мянган төгрөгөөр илүү бүртгэсэн байна.

Иймд тус компаний төрийн эзэмшлийн 21 хувийг 5,375.9 мянган төгрөгөөр илүү бүртгэснийг залруулж, зөв дүнгээр бүртгэх нь зүйтэй.

#### **В. “Гурван сайхан” ХХК-д оруулсан хөрөнгө оруулалт**

2.1.6. Төрийн өмчийн хорооны 2009 оны 5 дугаар сарын 28-ны өдрийн 204 дүгээр тогтоолоор “Гурван сайхан” ХХК-ий нийт хувьцааны төрийн эзэмшлийн 15 хувийн төлөөллийг “Мон-Атом” ХХК-д шилжүүлсэн байна.

2.1.7. “Гурван сайхан” ХХК-ий улсын бүртгэлийн гэрчилгээнд бүртгэгдсэн 10.0 сая төгрөгийн хувь нийлүүлсэн хөрөнгийн төрийн эзэмшлийн 15 хувийн төлөөлөл буюу 1,500.0 мянган төгрөгийг “Мон Атом” ХХК бүртгэж, санхүүгийн тайланд тусгасан байна.

### Бүлэг 3. Авлага, өр төлбөрийг анхан шатны баримтгүйгээр данснаас хасч, нийт өр төлбөрийн 81.2 хувийг харилцагч байгууллагатай тооцоо нийлж, баталгаажуулаагүй байна

“Мон Атом” ХХК 2016 оны жилийн эцэст нийт 7,513.5 сая төгрөгийн өр төлбөрийн үлдэгдэлтэй байна.

Нийт өр төлбөрийн өсөлтийн талаарх мэдээллийг графикаар харуулбал,

График 1



Эх сурвалж: “Мон Атом” ХХК-ий 2009-2016 оны санхүүгийн тайлан

#### 3.1. Авлага, өр төлбөрийг анхан шатны баримтгүйгээр данснаас хасчээ

3.1.1. “Мон Атом” ХХК 2012 онд геологийн урьдчилсан таамаг судалгаа, эрэл хайгуулын ажил гүйцэтгүүлэхээр “Мон Зим Интернэшнл” ХХК-тай 1,090.0 мянган ам.долларын гэрээ байгуулж, гэрээний дагуу 2013 онд 981.0 мянган ам.долларыг төлжээ.

3.1.2. Гэрээт ажлын үлдэгдэл төлбөр болох 109.0 мянган ам.долларыг 2013-2016 оны 3 дугаар улирал хүртэл санхүүгийн тайланд өглөгөөр тусгаж ирсэн боловч тооцоо нийлж, баталгаажуулаагүй байгаа нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.6<sup>4</sup>-д заасныг зөрчсөн байна. /тус гэрээт ажлын талаар 4 дүгээр бүлэгт дэлгэрэнгүй дурдсан болно/

3.1.3. Гүйцэтгэх захирлын үүргийг түр орлон гүйцэтгэгчийн 2016 оны 12 дугаар сарын 26-ны өдрийн 21/08 дугаар тушаалыг үндэслэн “Мон Зим интернейшнл” ХХК-д төлөх 109.0 мянган ам.доллар буюу 220.2 сая төгрөгийн хайгуул, тандалт судалгааны ажлын үлдэгдэл төлбөрийг анхан шатны баримтгүйгээр, тооцоо нийлж баталгаажуулалт хийлгүй шууд хасжээ.

<sup>4</sup> эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах

3.1.4. Ийм их хэмжээний төлбөрийг данснаас шууд хассан, “Мон Зим интернейшнл” ХХК авлагаа “Мон Атом” ХХК-иас олон жил нэхэмжлэхгүй явж ирсэн нь хэвийн бус, эрсдэл үүссэн байж болзошгүйг илтгэж байна.

Тиймээс “Мон Зим интернейшнл” ХХК нь 1,090.0 мянган ам.долларын өртөг бүхий геологийн урьдчилсан таамаг судалгаа, эрэл хайгуулын ажил гүйцэтгүүлэх гэрээт ажлын төлбөрийг орлого, татварын тайландаа зохих ёсоор тусгасан, холбогдох татвар хураамжийг төлсөн эсэхийг шалгуулахаар Татварын ерөнхий газарт 2017 оны 7 дугаар сарын 18-ны өдрийн 1258 дугаар албан бичгээр хандсан болно. /албан бичгийг хавсаргав/

3.1.5. 2016 оны жилийн эцэст Чингэлтэй дүүргийн Татварын хэлтсийн тооцоо нийлсэн актаар баталгаажсан 95.4 сая төгрөгийн НӨАТ-ын авлагыг ямар нэгэн зөвшөөрөл, шийдвэргүйгээр, анхан шатны баримтын бүрдэлгүйгээр данснаас хассан, Юнивишн ХХК-ий дансанд байршуулсан барьцааны 950.0 мянган төгрөгийн авлагыг санхүүгийн тайланд тусгаагүй зөрчил илэрлээ.

Цаашид Чингэлтэй дүүргийн татварын хэлтэс болон Юнивишн ХХК-тай тооцоо нийлж, авлагыг баталгаажуулан санхүүгийн тайланд залруулж бүртгэхийг компаний удирдлагад зөвлөв.

3.1.6. 2016 оны хагас жилийн санхүүгийн тайланд цалингийн өглөгийг албан хаагчдаар гарын үсэг зуруулсан жагсаалтаас 23,243.1 мянган төгрөгөөр дутуу, ажилчдад олгох ажлаас халагдсаны тэтгэмжийг 50.0 мянган төгрөгөөр илүү тайлагнасан байна.

3.1.7. Гүйцэтгэх захирлын 2016 оны 5 дугаар сарын 31-ний өдрийн 28 дугаар тушаалаар нийт 40 ажилтныг ажлаас чөлөөлж, 1 сарын тэтгэмж олгохоор шийдвэрлэн 40.0 сая төгрөгийн, Гүйцэтгэх захирлын үүргийг түр орлон гүйцэтгэгчийн 2016 оны 11 дүгээр сарын 3-ны өдрийн 18/08 дугаар тушаалаар 2016 оны 7 дугаар сарын 1-нээс өмнө ажиллаж байсан ажилчдад олгогдоогүй цалинд алданги тооцож олгохыг зөвшөөрсний дагуу 106.1 сая төгрөгийн, нийт 146.1 сая төгрөгийн өр төлбөр нэмэгдсэн байна.

Цалин, тэтгэмжийг дахин тооцоолж, тооцоо нийлж баталгаажуулан өр төлбөрийг үнэн зөвөөр санхүүгийн тайланд тусгаж, барагдуулах ажлыг зохион байгуулахыг компаний удирдлагад зөвлөв.

### **3.2. Нийт өр төлбөрийн 81.2 хувийг хөрөнгө оруулсан компани болон харилцагч байгууллагатай тооцоо нийлж, баталгаажуулаагүй байна**


3.2.1. “Мон Атом” ХХК-д хөрөнгө оруулсан болон харилцагч байгууллага, иргэдийн 6,124.7 сая төгрөгийн өр төлбөр буюу нийт өр төлбөрийн 81.2 хувийг тооцоо нийлж, баталгаажуулаагүй байна.

3.2.2. “Од бүртгэл аудит” ХХК 2016 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд хийсэн аудитын явцад тулган баталгаажуулах захидлаар тэдгээрээс нийт 450.1 сая төгрөгийн өр төлбөрийг баталгаажуулжээ.

Цаашид Нягтлан бодох бүртгэлийн тухай хуульд заасны дагуу санхүүгийн тайлан бэлтгэх үед харилцагч, байгууллагуудтай үүссэн авлага, өр төлбөрийг тооцоо нийлж баталгаажуулж хэвших шаардлагатай.

#### Бүлэг 4. Компаний удирдлага хамтран ажиллах гэрээний санхүүжилт, зээлийн эргэн төлөх эх үүсвэр, үр ашгийг тооцоогүйгээс Монгол Улсад 7.5 тэрбум төгрөгийн өр төлбөр үүсгэсэн байна

“Мон Атом” ХХК-ий 2016 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан дахь нийт өр төлбөрийн 70 хувь буюу 5,256.8 сая төгрөг нь урт хугацаатай өр төлбөр, 30 хувь буюу 2,256.7 төгрөг нь богино хугацаатай өр төлбөр байна.



Эх сурвалж: “Мон Атом” ХХК-ий 2009-2016 оны санхүүгийн тайлан

#### 4.1. Компаний тухай хуулийг зөрчин хамтран ажиллах гэрээ байгуулжээ

4.1.1. “Компанийн тухай” хуулийн 76 дугаар зүйлийн 76.1.16<sup>5</sup> дах заалтыг зөрчин Төлөөлөн удирдах зөвлөлийн шийдвэр, зөвшөөрөлгүйгээр “Мон Атом” ХХК-ий гүйцэтгэх захирлаар ажиллаж байсан Ж.Билэгсайхан “Ураниум Индастри” ХК-ий ерөнхий захирал Милан Клежкатай 2012 оны 11 дүгээр сарын 16-ны өдөр 3.0 сая ам.долларын санхүүжилт бүхий “Хамтран ажиллах гэрээ”-г байгуулсан байна.

4.1.2. Тус гэрээгээр “Мон Атом” ХХК хамтын ажиллагаа, эрэл тандалт судалгааны үр дүнгээр шинээр цацраг идэвхт ашигт малтмалын илэрц олдсон Ховд, Баян-Өлгий, Увс аймгуудын нутаг дэвсгэр дэх талбайд цацраг идэвхт ашигт малтмалын хайгуулын тусгай зөвшөөрлийг холбогдох хууль, тогтоомжийн дагуу өөрийн нэр дээр авах, хамтарсан эрэл, тандалт судалгааны ажил гүйцэтгэсэн талбайгаас сонгон авч хайгуулын ажил явуулах, хайгуулын тусгай зөвшөөрөл авсан талбайд “Ураниум Индастри” ХК-тай хамтран ажиллах, талуудын хайгуулын ажил гүйцэтгэсэн цацраг идэвхт ашигт малтмалын эрэл, тандалт судалгаа хайгуулын ажлын явцад цацрагт идэвхт ашигт малтмалын нөөц тогтоогдсон бол хайгуул, ашиглалт, олборлолтын хамтарсан компани байгуулах нөхцөлийг хүлээн зөвшөөрчээ. Тус гэрээнд 2 удаа өөрчлөлт оруулж, дараах нөхцөлүүдийг нэмжээ. Үүнд:

- 2012 оны 12 дугаар сарын 20-ны өдөр оруулсан өөрчлөлтөөр “цацраг идэвхт ашигт малтмалын илэрц олдсон талбайд хайгуулын тусгай зөвшөөрлийг хуулийн дагуу авч, хамтарсан компани болох “Мон Чех Ураниум” ХХК-д шилжүүлэх”;

<sup>5</sup> 76.1.16. Энэ хуулийн арван нэгдүгээр бүлэгт заасны дагуу их хэмжээний хэлцэл хийх зөвшөөрөл олгох;



- 2013 оны 4 дүгээр сарын 19-ны өдөр оруулсан өөрчлөлтөөр “хэрэв Хэнтий аймгийн Норовлин суманд хайгуулын лиценз хуулийн дагуу олж авсан тохиолдолд “Мон Чех Ураниум” ХХК-д шилжүүлэх”.

4.1.3. Хамтран ажиллах гэрээний дагуу “Мон Атом” ХХК нь “Ураниум индастри” ХК-иас 2012 оны 12 дугаар сард 750.0, 2013 оны 1 дүгээр сард 1,250.0 мянган ам.долларыг тус тус шилжүүлснийг хүлээн авч, урт хугацаат өр төлбөрөөр бүртгэж, тайлагнасан байна.

4.1.4. “Ураниум Индастри” ХК-аас хамтран ажиллах гэрээний дагуу хүлээн авсан 2.0 сая ам.долларын зарцуулалтыг харуулбал:

Хүснэгт 3.Зарцуулалтын тайлан

| д/д                    | Данс                                              | Зарцуулалт<br>/ам.доллараар/ | Зарцуулалт<br>/төгрөгөөр/ | Хувь           |
|------------------------|---------------------------------------------------|------------------------------|---------------------------|----------------|
| 1                      | Хайгуулын ажлын төлбөр /Monzim international LLC/ | 981,000                      | 1,407,284,830             | 49.05%         |
| 2                      | Зээл төлөв Голомт                                 | 429,063                      | 600,383,854               | 21.45%         |
| 3                      | Цалингийн зардал                                  | 210,264                      | 336,142,303               | 10.51%         |
| 4                      | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил                        | 64,828                       | 103,638,000               | 3.24%          |
| 5                      | Үндсэн хөрөнгө худалдан авалт                     | 59,514                       | 95,144,055                | 2.98%          |
| 6                      | НДШ                                               | 55,585                       | 88,862,579                | 2.78%          |
| 7                      | Зар сурталчилгааны зардал                         | 31,385                       | 50,175,000                | 1.57%          |
| 8                      | Сургалтын зардал                                  | 29,995                       | 47,951,786                | 1.50%          |
| 9                      | Албан томилолт                                    | 29,391                       | 46,987,258                | 1.47%          |
| 10                     | Түрээсийн төлбөр/Автомашин/                       | 27,259                       | 43,578,620                | 1.36%          |
| 11                     | ХХОАТ                                             | 23,884                       | 38,183,103                | 1.19%          |
| 12                     | Зээл төлөв Эрдэнэс МГЛ                            | 21,354                       | 34,137,846                | 1.07%          |
| 13                     | Ашиглалтын зардал                                 | 13,278                       | 21,226,632                | 0.66%          |
| 14                     | Бусад зардал                                      | 7,899                        | 12,471,722                | 0.39%          |
| 15                     | Шуудан холбооны зардал                            | 6,333                        | 10,124,161                | 0.32%          |
| 16                     | Тэтгэмжийн зардал                                 | 5,852                        | 9,355,640                 | 0.29%          |
| 17                     | Шатахууны зардал                                  | 3,115                        | 4,980,000                 | 0.16%          |
| <b>Нийт зарцуулалт</b> |                                                   | <b>2,000,000</b>             | <b>2,950,627,388</b>      | <b>100.00%</b> |

Эх сурвалж: “Мон Атом” ХХК-ийн 2013 оны харилцах дансны хуулга, гүйлгээний журнал

4.1.5. “Ураниум Индастри” ХК-д төлөх 5,265.8 сая төгрөгийн урт хугацаат өр төлбөрийн үлдэгдлийг хэрхэн шийдвэрлэх талаар тус компаний ТУЗ-ийн дарга, орлогч дарга, “Мон Атом” ХХК-ий гүйцэтгэх захирал, дэд захирал нарын 2017 оны 2 дугаар сарын 17-ны өдрийн хамтарсан хурлын 01/2017 дугаар шийдвэрээр “Мон Чех Ураниум” ХХК-д оруулсан хөрөнгө оруулалтаар бүртгэхээр харилцан тохиролцсон нь “Мон Атом” ХХК-ий дүрмийн 8 дугаар зүйлд заасан гүйцэтгэх удирдлагын эрх хэмжээнд шийдвэрлэх асуудалд хамаарахгүй байна.

Иймд дээрх асуудлыг компаний Төлөөлөн удирдах зөвлөлд танилцуулж, гарсан шийдвэрийг үндэслэн нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайланд зохих ёсоор тусгахыг зөвлөв.

#### 4.2. Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийг зөрчин сонгон шалгаруулалт явуулахгүйгээр шууд гэрээ байгуулжээ

4.2.1. Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийг зөрчин тендер зарлахгүйгээр дараах гэрээнүүдийг шууд байгуулсан байна. Үүнд:

- 2010 оны 1 дүгээр сарын 06-ны өдөр тухайн үед Гүйцэтгэх захирлаар ажиллаж байсан Р.Бадамдамдин “Мон Зим Интернэшнл” ХХК-тай 280.0 мянган ам.долларын өртөг бүхий геологийн урьдчилсан таамаг судалгаа, эрэл хайгуулын ажил гүйцэтгүүлэх 01/12 дугаар гэрээ;
- 2012 онд Гүйцэтгэх захирлаар ажиллаж байсан Ж.Билэгсайхан “Мон Зим Интернэшнл” ХХК-тай 1,090.0 мянган ам.долларын өртөг бүхий геологийн урьдчилсан таамаг судалгаа, эрэл хайгуулын ажил гүйцэтгүүлэх гэрээ /тус гэрээг байгуулсан сар, өдрийг бичээгүй, гэрээний дугаар байхгүй зөрчилтэй/;
- 2013 онд Гүйцэтгэх захирлаар ажиллаж байсан Э.Галбадрал “Тэнгэрийн Гэрэл” ХХК-тай 22.000.000 төгрөгийн дүн бүхий хөрөнгийн үнэлгээ хийлгэх ажил гүйцэтгүүлэх гэрээ.

4.2.2. Гадаад худалдаа, зуучлал, малын эм, тоног төхөөрөмжийн худалдаа эрхэлдэг “Мон Зим Интернэшнл” ХХК-тай байгуулсан 1,090.0 мянган ам.долларын геологийн урьдчилсан таамаг судалгаа, эрэл хайгуулын ажил гүйцэтгүүлэх гэрээний асуудлаар тухайн үед Гүйцэтгэх захирлаар ажиллаж байсан Ж.Билэгсайханд Авилгатай тэмцэх газар хэрэг үүсгэн шалгасан боловч тус хэргийг хэрхэн шийдвэрлэсэн талаарх мэдээллийг одоо болтол “Мон Атом” ХХК албан ёсоор аваагүй байна.

4.2.3. Аудитын явцад “Мон Атом” ХХК-ий талаар “Цөмийн энергийн газар”-т ажиллаж байсан мэргэжлийн инженерүүдтэй уулзалт зохион байгуулж, мэдээлэл солилцоход “Авилгатай тэмцэх газарт “Мон Зим интернэшнл” ХХК-д шилжүүлсэн 981.0 мянган ам.доллартай холбоотойгоор Ж.Билэгсайхан захирал шалгагдсан боловч “Мон Чех Ураниум” ХХК хохиролгүй гэсэн тодорхойлолт гаргаж өгснөөр хэрэг хаагдсан” гэсэн мэдээлэл өгсөн болно.

4.2.4. Тус хэргийн талаар аудитын явцад лавлагаа, тодруулга авахаар Авилгатай тэмцэх газарт албан бичиг явуулсан боловч хариу ирүүлээгүй.

4.2.5. “Мон Зим интернэшнл” ХХК-иар хийлгэсэн гэрээт ажлын тайлан гэх 2 хавтас материал “Мон Атом” ХХК-д байгаа боловч түүнийг тус ажлын бодит тайлан мөн эсэхийг аудитын явцад тогтоох боломжгүй байна.

Тус гэрээ, гүйцэтгэсэн ажлын талаар мэргэжлийн байгууллагад хандаж дүгнэлт гаргуулах, хэрэг үүсгэсэн шалгасан Авилгатай тэмцэх газарт хүсэлт гаргаж, эцэслэн шийдвэрлүүлэх шаардлагатай байна.

Аудитын явцад “Мон Зим интернэшнл” ХХК-тай байгуулсан 1,090.0 мянган ам.долларын геологийн урьдчилсан таамаг судалгаа, эрэл хайгуулын ажил гүйцэтгүүлэх гэрээ, гэрээний дагуу гүйцэтгэсэн ажлын гүйцэтгэл, ажлын хөлсний үлдэгдэл 109.0 мянган ам.доллар буюу 220.2 сая төгрөгийн өр төлбөрийг данснаас шууд хассан асуудлыг шалгуулахаар Цагдаагийн ерөнхий газрын Эрүүгийн цагдаагийн газрын Эдийн засгийн гэмт хэрэгтэй тэмцэх хэлтэст 2017 оны 7 дугаар сарын 18-ны өдрийн 1259 дугаар албан бичгээр хандсан болно. /албан бичгийг хавсаргав/



#### **4.3. Эргэн төлөх эх үүсвэр, үр ашгийг тооцохгүйгээр зээл авч, их хэмжээний өр төлбөр үүсгэсэн байна**

4.3.1. Голомт банкнаас 2010 онд 270.0 сая төгрөгийн, 2011 онд 650.0 сая төгрөгийн зээл авч үйл ажиллагааны зардалд зарцуулсан боловч, зээлийн эргэн төлөх графикт хугацаанд төлж чадаагүй байна.

4.3.2. Голомт банкны нэхэмжлэлээр Чингэлтэй дүүргийн Шүүхийн 2012 оны 8 дугаар сарын 23-ны өдрийн 1198 дугаар шүүгчийн захирамжаар 920.0 сая төгрөгийн үндсэн зээл, 135.7 сая төгрөгийн үндсэн хүү, 23.9 сая төгрөгийн нэмэгдүүлсэн хүү, нийт 1,079.6 сая төгрөгийг “Мон Атом” ХХК-иар төлүүлэх шийдвэр гарсан байна.

Голомт банкнаас зээл авахдаа зээлийг эргэн төлөх эх үүсвэр, үр ашгийг тооцоогүйгээс шалтгаалан их хэмжээний хугацаа хэтэрсэн зээл болон хүүгийн өр төлбөрийг үүсгэсэн байна.

Цаашид зээлийн эргэн төлөх эх үүсвэр, үр ашгийг тооцоолж, зээл авч байхыг компаний удирдлагад зөвлөв.

4.3.3. Төлөөлөн удирдах зөвлөл 2014 оны 6 дугаар сарын 13-ны өдөр Гүйцэтгэх захиралд “Ураниум Индастри” ХК-иас 200.0 мянган ам.доллар хүртэлх зээл авах зөвшөөрөл олгосон боловч 2015 оны 6 дугаар сарын 16-ны өдөр 251.0 мянган ам.долларын зээл авах гэрээг тухайн үед Гүйцэтгэх захирлаар ажиллаж байсан Э.Галбадрал зөвшөөрлөөс 51.0 мянган ам.доллараар хэтрүүлэн байгуулснаар өр төлбөрийн хэмжээ нэмэгдэхэд хүргэсэн байна.

Цаашид компаний дотоод хяналтыг сайжруулж, Төлөөлөн удирдах зөвлөлийн зөвшөөрлийг үндэслэн гэрээг байгуулахыг компаний удирдлагад зөвлөв.

#### **4.4. Зээлийн хүү болон ханшийн зөрүүг нягтлан бодох бүртгэлд үнэн зөв тусгаагүй байна**

4.4.1. “Мон Атом” ХХК нь “Ураниум Индастри” ХК-тай 2015 оны 6 дугаар сарын 16-ны өдөр байгуулсан зээлийн гэрээний дагуу 201.0 мянган ам.долларын зээл авсан, үлдэгдэл 50.0 мянган ам.долларыг өнөөг хүртэл аваагүй байна.

4.4.2. Дээрх зээлийн хүүний зардлыг нягтлан бодох бүртгэлд хуримтлуулж бүртгээгүй, ханшийн зөрүүг тооцож бүртгээгүй, санхүүгийн тайланд тусгаагүй байна.

## Аудитын дүгнэлт

“Мон Атом” ХХК-ий санхүүгийн удирдлагын үйл ажиллагаанд хийсэн эрсдэлийн аудитын дүнд үндэслэн дараахь дүгнэлт хийж байна. Үүнд:

1. “Мон Атом” ХХК-ий удирдлага санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн зөрчил, дутагдлыг арилгах ажил зохион байгуулаагүй, аудитаар өгсөн зөвлөмжийн 41.7 хувийг хэрэгжүүлээгүй байна.
2. “Мон Атом” ХХК хувь нийлүүлсэн хөрөнгө оруулалтыг нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, хууль, журмын дагуу бүрэн бүртгээгүй, санхүүгийн тайланд үнэн зөв тусгаагүй байна.
3. Төрийн өмчийн хорооноос хувь нийлүүлсэн хөрөнгө оруулалтыг зээлээр санхүүжүүлэх зөвшөөрөл аваагүйгээс “Мон Атом” ХХК “Зээлийн гэрээ”-ний дагуу шилжүүлсэн 51.0 мянган ам.долларыг “Мон Чех Уран” ХХК-д хувь нийлүүлсэн хөрөнгө оруулалт болон “Ураниум Индастри” ХК-д төлөх өр төлбөрөөр бүртгээгүй, санхүүгийн тайланд тусгаагүй байна.
4. “Мон-Атом” ХХК “Төв Азийн уран” ХХК-ий төрийн эзэмшлийг 750,552.2 мянган төгрөгөөр санхүүгийн тайланд бүртгэгдэхээр байхад тус компани 755,928.1 мянган төгрөгөөр буюу 5,375.9 мянган төгрөгөөр илүү бүртгэсэн байна.
5. Авлага, өр төлбөрийг анхан шатны баримтгүйгээр данснаас хассан байна.
6. Нийт өр төлбөрийн 81.2 хувийг хөрөнгө оруулсан компани болон харилцагч байгууллагатай тооцоо нийлж, баталгаажуулаагүй байна.
7. Компаний удирдлага хамтран ажиллах гэрээний санхүүжилт, зээлийн эргэн төлөх эх үүсвэр, үр ашгийг тооцоогүйгээс Монгол Улсад 7.5 тэрбум төгрөгийн өр төлбөр үүсгэсэн байна.
8. Гүйцэтгэх захирлаар ажиллаж байсан Ж.Билэгсайхан “Компанийн тухай” хуулийн 76 дугаар зүйлийн 76.1.16 дах заалтыг зөрчин “Ураниум Индастри” ХК-ий ерөнхий захирал Милан Клечкатай 2012 оны 11 дүгээр сарын 16-ны өдөр 3.0 сая ам.долларын санхүүжилт бүхий “Хамтран ажиллах гэрээ”-г Төлөөлөн удирдах зөвлөлийн шийдвэр, зөвшөөрөлгүйгээр байгуулсан байна.
9. “Ураниум Индастри” ХК-д төлөх 5,265.8 сая төгрөгийн урт хугацаат өр төлбөрийн үлдэгдлийг 2017 оны 2 дугаар сарын 17-ны өдрийн хамтарсан хурлын 01/2017 дугаар шийдвэрээр “Мон Чех Ураниум” ХХК-д оруулсан хөрөнгө оруулалтаар бүртгэхээр харилцан тохиролцсон нь “Мон Атом” ХХК-ий дүрмийн 8 дугаар зүйлд заасан гүйцэтгэх удирдлагын эрх хэмжээний хүрээнд шийдвэрлэх асуудалд хамаарахгүй байна.
10. Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийг зөрчин тендер зарлахгүйгээр шууд гэрээ байгуулсан байна.

## **Аудитын зөвлөмж**

Аудитын дүгнэлтэд үндэслэн дараахь арга хэмжээ авч хэрэгжүүлэхийг дор дурдсан байгууллага, албан тушаалтанд зөвлөж байна.

### **“Эрдэнэс Монгол” ХХК-ий Төлөөлөн удирдах зөвлөлд:**

1. “Мон Атом” ХХК-ий санхүүгийн удирдлагын үйл ажиллагаанд хийсэн аудитаар илэрсэн зөрчил, дутагдлыг арилгуулах, аудитаас өгсөн зөвлөмжийн хэрэгжилтэд хяналт тавьж, гүйцэтгэл, үр дүнг тооцож ажиллах;
2. Хамтран ажиллах гэрээний санхүүжилт, зээлийн эргэн төлөх эх үүсвэр, үр ашгийг тооцоогүйгээс Монгол Улсад үүсгэсэн 7.5 тэрбум төгрөгийн өр төлбөрийг хэрхэн барагдуулах талаар Засгийн газарт танилцуулж, шийдвэрлүүлэх;
3. Аудитын тайланд дурдагдсан зөрчлийг давтан гаргуулахгүй байхад анхаарч, компаний гүйцэтгэх удирдлага, санхүүгийн үйл ажиллагаанд тавих дотоод хяналтыг сайжруулж, үр дүнг тооцож ажиллах.

### **“Мон Атом” ХХК-ий гүйцэтгэх захиралд:**

1. Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг Нягтлан бодох бүртгэлийн болон Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт, Сангийн сайдын баталсан журам, зааварт нийцүүлэн боловсруулж, батлуулж, мөрдөх;
2. “Мон Чех ураниум” ХХК-д “Ураниум Индастри” ХК-иас шилжүүлсэн 51.0 мянган ам.долларын гүйлгээтэй холбоотой асуудлыг Төлөөлөн удирдах зөвлөлд танилцуулж, холбогдох зөвшөөрлийг авч, хөрөнгө оруулалт болон өр төлбөрийг хүлээн зөвшөөрч бүртгэн, санхүүгийн тайланд тусгах;
3. 2017 оны 3 дугаар улиралд багтаан 1 дүгээр хавсралтад дурдагдсан нийт 101,760.0 мянган төгрөг, 252.0 мянган ам.долларын залруулах бичилтийг хийх;
4. “Мон Атом” ХХК-д хөрөнгө оруулсан болон харилцагч байгууллага, иргэдийн авлага, өр төлбөрийг Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.6-д заасны дагуу санхүүгийн тайлан гаргахын өмнө тооцоо нийлж, баталгаажуулж хэвших;
5. Санхүүгийн тайланд тусгагдсан ажиллагсдад олгох цалин, тэтгэмжийн 597.9 сая төгрөгийн өр төлбөрийг дахин тооцоолж, баталгаажуулан үнэн зөв бүртгэж, өр төлбөрийг барагдуулах.
6. “Мон Зим Интернэшнл” ХХК-тай байгуулсан нийт 1,090.0 мянган ам.долларын ажил гүйцэтгүүлэх гэрээ хуульд нийцсэн эсэх, гэрээний дагуу хийсэн ажлын гүйцэтгэл бодитой эсэх, анхан шатны баримтгүйгээр 220.2 сая төгрөгийн өглөгийг данснаас хассан асуудлыг Авилгатай тэмцэх газарт хандан эцэслэн шийдвэрлүүлэх;
7. Ураниум Индастри" ХК-д төлөх 5,265.8 сая төгрөгийн урт хугацаат өр төлбөрийн үлдэгдлийг компаний Төлөөлөн удирдах зөвлөлөөр хэлэлцүүлж, шийдвэр гаргуулж, хэрэгжүүлэх;

8. Санхүүгийн удирдлагын үйл ажиллагаанд хийсэн аудитаар илэрсэн зөрчил, дутагдлыг арилгах, аудитаас өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөө гаргаж, гүйцэтгэлийг тооцож, мэдээллийг 2017 оны 12 дугаар сарын 10-ны дотор ҮАГ-т ирүүлэх.

Жич: Аудитын тайлангийн 3 дугаар бүлэгт дурдагдсан асуудлыг шалгуулахаар Татварын ерөнхий газарт 2017 оны 7 дугаар сарын 18-ны өдрийн 1258 дугаар албан бичгээр, 4 дүгээр бүлэгт дурдагдсан асуудлыг шалгуулахаар Цагдаагийн ерөнхий газрын Эрүүгийн цагдаагийн газрын Эдийн засгийн гэмт хэрэгтэй тэмцэх хэлтэст 2017 оны 7 дугаар сарын 18-ны өдрийн 1259 дугаар албан бичгээр тус тус хандсан болно.

**Санхүүгийн тайланд залруулах шаардлагатай асуудлууд**

| №               | ЗАЛРУУЛАХ АСУУДАЛ                                                                                                                                                                                                                                   | /мянган төгрөгөөр/<br><b>МӨНГӨН ДҮН</b>                         |
|-----------------|-----------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|-----------------------------------------------------------------|
| 1               | “Мон Атом” ХХК-ий “Мон Чех ураниум” ХХК-д хувь нийлүүлсэн хөрөнгийн 51.0 мянган ам.долларыг хөрөнгө оруулалт болон "Ураниум Индастри" ХК-д өгөх өр төлбөрөөр бүртгэж, залруулах бичилтийг хийх;                                                     | 51.0 мянган ам.доллар                                           |
| 2               | “Төв Азийн уран” ХХК-ний хувь нийлүүлсэн хөрөнгийн төрийн өмчийн төлөөлөлд хамаарах дүнг 5,375.9 мянган төгрөгөөр илүү тусгасныг залруулах;                                                                                                         | 5,375.9                                                         |
| 3               | 2016 оны жилийн эцсийн байдлаар үүссэн 95.4 сая төгрөгийн НӨАТ-ын авлагыг данснаас хассаныг залруулж, нягтлан бодох бүртгэлд авлагаар бүртгэх;                                                                                                      | 95,434.1                                                        |
| 4               | “Юнивишн” ХХК-ий дансанд байршуулсан барьцааны 950.0 мянган төгрөгийг залруулж, санхүүгийн тайланд авлагаар бүртгэх;                                                                                                                                | 950.0                                                           |
| 5               | “Мон Атом” ХХК нь “Ураниум Индастри” ХК-тай 2015 оны 6 дугаар сарын 16-ны өдөр байгуулсан зээлийн гэрээний дагуу хүлээн авсан 201.0 мянган ам.долларын зээлийн хүүг гэрээнд заасан нөхцөлийн дагуу бүртгэж, санхүүгийн тайланд хуримтлуулан тусгах; | 201.0 мянган ам.доллар                                          |
| <b>НИЙТ ДҮН</b> |                                                                                                                                                                                                                                                     | <b>101,760.0</b> мянган төгрөг<br><b>252.0</b> мянган ам.доллар |



МОНГОЛ УЛСЫН  
ЕРӨНХИЙ АУДИТОРЫН  
ТУШААЛ

2017 оны 08 сарын 29 өдөр

Дугаар А/146

Улаанбаатар хот

Аудитын тайланг баталгаажуулах тухай


Төрийн аудитын тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.4.7 дахь заалт, 19 дүгээр зүйлийн 19.3.3 дахь заалт, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2003 оны 53 дугаар тушаалаар баталсан “Гүйцэтгэлийн аудитын тайланг хянан баталгаажуулах журам батлах тухай” журмын 4 дүгээр зүйлийн 4.2 дахь заалт, 2016 оны А/92 дугаар тушаалаар баталсан “Гүйцэтгэлийн аудитын журам”-ын 12 дугаар зүйлийн 12.39 дэх заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. “Мон Атом” төрийн өмчит хязгаарлагдмал хариуцлагатай компаний санхүүгийн удирдлагын үйл ажиллагаанд хийсэн эрсдэлийн аудитын тайланг хавсралтаар баталгаажуулсугай.

2. Аудитын тайланг “Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар”, “Эрдэнэс Монгол” ХХК, “Мон Атом” төрийн өмчит хязгаарлагдмал хариуцлагатай компанид тус тус хүргүүлсүгэй.

3. Аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлэх арга хэмжээ авч, үр дүнг 2017 оны 12 дугаар сарын 10-ны дотор Үндэсний аудитын газарт ирүүлэхийг “Мон Атом” төрийн өмчит хязгаарлагдмал хариуцлагатай компаний Гүйцэтгэх захирлын үүрэг гүйцэтгэгч /Д.Далайжаргал/, аудитын тайланд тусгагдсан зөвлөмжийн хэрэгжилтэд хяналт тавьж, үр дүнг тооцон ажиллахыг Гүйцэтгэлийн аудитын газрын захирал, тэргүүлэх аудитор /М.Давааням/, аудиттай холбоотой ажлын болон нотлох баримтыг тайлан баталгаажсанаас хойш 14 хоногийн дотор архивын нэгж болгон Үндэсний аудитын газрын архивт хүлээлгэн өгөхийг аудитын баг /Б.Долгорсүрэн/-т тус тус үүрэг болгосугай.

МОНГОЛ УЛСЫН  
ЕРӨНХИЙ АУДИТОР



Д.ХҮРЭЛБААТАР

\\10.10.10.20\Bichig\_Khereg\Tushaal\2017\0829GAG4.Docx

070919





**МОНГОЛ УЛСЫН  
ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР**

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг  
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр  
Утас: 26-04-37, Факс: 62-26-32-30  
E-mail: info@audit.gov.mn

2017.07.18 № 1258  
танай \_\_\_\_\_ -ны № \_\_\_\_\_ -т

ЦАГДААГИЙН ЕРӨНХИЙ ГАЗРЫН  
ЭРҮҮГИЙН ЦАГДААГИЙН ГАЗРЫН  
ЭДИЙН ЗАСГИЙН ГЭМТ ХЭРЭГТЭЙ  
ТЭМЦЭХ ХЭЛТЭСТ

**Мэдээлэл хүргүүлэх тухай**

Үндэсний аудитын газрын Гүйцэтгэлийн аудитын газраас “Мон Атом” ХХК-ийн санхүүгийн удирдлагын үйл ажиллагаанд эрсдэлийн аудит хийлээ.

Тус компани 2012 онд Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийг зөрчин тендер шалгаруулахгүйгээр “Мон Зим интернэшнл” ХХК-тай 1,090.0 мянган ам.долларын өртөг бүхий геологийн урьдчилсан таамаг судалгаа, эрэл хайгуулын ажил гүйцэтгүүлэх гэрээ байгуулсан байна. Тус гэрээг байгуулсан огноо, гэрээний дугаар байхгүй байна.

“Мон Атом” ХХК 2013 онд гэрээний дагуу ажлын хөлсийг 2 дугаар сарын 08-нд 545.0 мянган ам.доллар, 3 дугаар сарын 18-нд 218.0 мянган ам.доллар, 8 дугаар сарын 19-нд 218.0 мянган ам.доллар, нийт 981.0 мянган ам.долларыг шилжүүлж, үлдэгдэл 109.0 мянган ам.долларыг “Мон Зим интернэшнл” ХХК-д төлөх өглөгөөр бүртгэгдэж иржээ. Тус гэрээт ажлын гүйцэтгэл, тайлан, нотлох баримт тус компани дээр байхгүй байна.

“Мон Атом” ХХК 2013-2016 онд дээрх 109.0 ам.долларын өглөгийг тооцоо нийлж байгаагүй, өр төлбөрийг баталгаажуулаагүй байх бөгөөд “Мон Зим интернэшнл” ХХК уг төлбөрийг идэвхитэй нэхэмжлээгүй байна.

“Мон Атом” ХХК нь гүйцэтгэх захирлын үүрэг гүйцэтгэгчийн 2016 оны 12 дугаар сарын 26-ны өдрийн 21/08 дугаар тушаалыг үндэслэн тус өр төлбөрийг шууд хассан байна.

Иймд хууль, журам зөрчин байгуулсан хүчин төгөлдөр бус гэрээг үндэслэн их хэмжээний төлбөрийн гүйлгээ хийгдсэн байх магадлалтай байх тул шалган тогтоож, хариу ирүүлнэ үү.

Жич: Аудитын тайлангийн хувийг хуулбарлан хүргүүлэв.

ЕРӨНХИЙ АУДИТОРЫН ОРЛОГЧ



С.ОЮУНБИЛЭГ

\\10.10.10.20\Bichig\_Kheregl\Yawsan\_Bichig\2017\0717GAG08.Docx





**МОНГОЛ УЛСЫН  
ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР**

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг  
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр  
Утас: 26-04-37, Факс: 62-26-32-30  
E-mail: info@audit.gov.mn

2017.07.18 № 1259  
танай \_\_\_\_\_ -ны № \_\_\_\_\_ -т

Мэдээлэл хүргүүлэх тухай

ТАТВАРЫН ЕРӨНХИЙ ГАЗАРТ

Үндэсний аудитын газрын Гүйцэтгэлийн аудитын газраас “Мон Атом” ХХК-ийн санхүүгийн удирдлагын үйл ажиллагаанд эрсдэлийн аудит хийлээ.

Тус компани 2012 онд “Мон Зим интернэшнл” ХХК-тай 1,090.0 мянган ам.долларын өртөг бүхий геологийн урьдчилсан таамаг судалгаа, эрэл хайгуулын ажил гүйцэтгүүлэх гэрээ байгуулж, ажлын хөлсийг дараах байдлаар шилжүүлсэн байна. Үүнд:

- 2013 оны 2 дугаар сарын 08-нд 545.0 мянган ам.доллар,
- 2013 оны 3 дугаар сарын 18-нд 218.0 мянган ам.доллар,
- 2013 оны 8 дугаар сарын 19-нд 218.0 мянган ам.доллар.

2013 онд “Мон Зим интернэшнл” ХХК нь дээр дурдсан нийт 981.0 мянган ам.долларын орлогыг санхүүгийн тайландаа тусгаж, хуулийн дагуу албан татвар төлсөн эсэхийг шалгаж, хариу ирүүлнэ үү.

ЕРӨНХИЙ АУДИТОРЫН ОРЛОГЧ



С.ОЮУНБИЛЭГ

\\10.10.10.20\Bichig\_Kheregi\Yawsan\_Bichig\2017\0717GAG09.Docxx

[illegible]